

Ван Го Вэй “Монголын нууц товчоон”-ыг харгуулан  
залруулга хийсэн тухай

Улаан\*

Дундад улсын Төрийн номын сангийн ховор дэвтрийн хэлтэст Ван Го Вэй харгуулсан “Монголын нууц товчоон” (дараагаар “Нууц товчоон” гэж дөхөмчилнө.)-ы хоёр дэвтэр хадгалж байх бөгөөд суурь дэвтэр нь бүр “Е Дэ Хүй”, “Гуань гү тан”-гийн барлал (дараагаар “Е”-гийн дэвтэр гэж дөхөмчилнө) билээ. Эдгээр дэвтрийн микрофильмийн номер нь 02192, хийгээд 02193 болно.

Суурь дэвтэрт Ван Го Вэй хийсэн тодорхойлолтоор бол, энэхүү дэвтрийг 1925 оны 8 сар (аргын улирлын 9 сар)-аас 1926 оны 10 сар (аргын улирлын 11 сар) болтол харгуулж, түрүү дэвтэр (дараагаар “А” дэвтэр гэж дөхөмчилнө)-ийг 1925 оны 8 сараас 9 сар хүртэл (аргын улирлын 9-өөс 10 сар хүртэл) анх харгуулж<sup>1</sup>, хоёрдахь дэвтэр (дараагаар “В” дэвтэр гэж дөхөмчилнө)–ийг 1925 оны 10 сар (аргын улирлын 11 сар)-д анх харгуулж,<sup>2</sup> 1926 оны 10 сар (аргын улирлын 11 сар)-д хоёр дэвтэрт дахин нөхвөр харгуулга хийсэн байна.<sup>3</sup> Харгуулахдаа Ван Го Вэй урьдаар “Лянь Юнь И” цуврал дахь дэвтрээр харгуулах дэвтэр болгож нэг удаа засвар оруулаад, дэмий удалгүй “Е”-гийн дэвтэр дэх хятад эхийн галиглалаар үндэс болгон бас нэгэн удаа харгуулж, “зохих тооны үг өгүүлбэр нэмж” нэг жилийн дараа Хань Фэнь Лоу асарт хадгалж байсан Гү Гуан Чи-гийн хянан хуулуулсан гар бичмэл<sup>4</sup> (дараагаар “Гү”-гийн дэвтэр гэж дөхөмчилнө) –ийг зээлж олсноор тус дэвтрийг үндэслэн дахин нэг удаа хянаж үзээд, “зохих тооны үсгийг залруулжээ.”<sup>5</sup>

\* БНХАУ-ын Нийгмийн Шинжлэх Ухааны Академи, Үндэсний судлал ба Хүн судлалын хүрээлэн

<sup>1</sup> «Юань Чао Ми Ши», Шанву хэвлэлийн “Шифү Зүнган” цувралын гутгаар эмхэтгэлд оруулсан Гү Гуан Чигийн хянан хуулуулсан дэвтрийн гэрэлзураглан хэвлүүлсэн хуулбар, Шанхай, 1936.

<sup>2</sup> Күрибаяши Хитоши, Чойжинжав: «Монголын нууц товчооны бүх монгол үгс, тайлбаруудын хэлхээс», Сэндай, 2001.

<sup>3</sup> Элдэнтэй, Оюундалай: «Монголын нууц товчооны харгуулсан дэвтэр», Хөххот, 1980.

<sup>4</sup> «Юань Чао Ми Ши гурван зүйлийн дэвтэр», Тайвэй, 1975.

<sup>5</sup> Лувсанданзаны «Алтан товч», гэрэл зураглан хэвлүүлсэн хуулбар, Улаанбаатар, 1990.

Ван Го Вэй хэдэн талаас харгуулалт хийсэн байна.

*Нэгдүгээрт*, голдуу “Е”-гийн дэвтрийн эх дэвтэр болох “Гү”-гийн дэвтрээр “Е”-ийн дэвтрийн ташаа сийлмэлийг залруулаад,<sup>6</sup> “*Лянь Юнь И*» цувралын дэвтэр (*Тухайлбал Чжан Мугийн арван тавтын товч хятадчилгын дэвтэр*)-т хятад залруулга хийжээ.<sup>7</sup>

*Хоёрдугаарт*, голдуу “Е”-гийн дэвтэр хийгээд “Гү”-гийн дэвтрийн урьд хождын үг өгүүлбэр (*хятад эхийн галиглал, тухайлбал Ван Го Вэйн хэлдэг «монгол эх» багтана*) –ийг үндэслэн залруулга ба нөхвөр орчуулга хийсэн байна.<sup>8</sup>

*Гуравдугаарт*, «*Шэн-у Цинь-чжэн-лу*» (*Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл*)-ийг үндэслэн залруулга хийжээ.<sup>9</sup> Харгуулж залруулахдаа голдуу хоёр зүйлийн зүүлт хийх аргыг хэрэглэжээ. Нэг арга нь хүснэгийн гадна залруулга бичиж (*заримдаа залруулга хийсэн дөхөм тэмдэглэл дагалдуулах*), нөгөө арга нь хүснэгийн дотор, үгийн гажууд залруулга бичдэг.<sup>10</sup>

Бүртгэлээр<sup>11</sup> Ван Го Вэйн залруулга нийт бараг 260 гаруй газар буй. Үүнд “А” дэвтэрт хийсэн залруулга бараг 147 газар, “В” дэвтэрт хийсэн залруулга бараг 117 газар (*давхардсан залруулга багтахгүйгээр*) байж, “Е”-гийн дэвтрийг залруулсан нь бараг 99 газар, “Гү”-гийн дэвтрийг залруулсан нь 165 газар (“*Е*”-гийн дэвтрийг үндэслэн “*Гү*”-гийн дэвтрийг зассан 4 газар багтаж буй) байна.

Харгуулан нэмсэн газар нийт 70 гаруй буй. Үүнд “А” дэвтэрт нэмсэн газар бараг 19, “В” дэвтэрт нэмсэн газар бараг 54 (*давхардсан залруулга багтахгүй*). Харгуулж зассан хэвчээ нь бүх дэвтрийг хамарч, үүнд хятад эхийн галиглал, хажуу дахь хятад хадмал, товч хятадчилга зэрэг гурван хэсгийг багтааж байна.<sup>12</sup>

Хятад галиглалыг 84 газар засаж, 8 газар нөхвөрлөв. Хятад хадмалыг 144 газар засаж, 54 газар нөхвөрлөв.

Товч хятадчилгыг 36 газар засаж, 11 газар нөхвөрлөв.

Буруудсан, тонгорсон, илүүдсэн, орхигдсон, буруу холбосон зэргээр зүйл хуваан, Ван Го Вэйн харгуулан зассан зүйлээс жишээ татвал доорхи мэт:<sup>13</sup>

## Нэг. Буруудсан

### 1. Хятад галиглалд:

qašuiqun→qamuqun	(§21,01:13:06),
üčüü→üčügen	(§35,01:21:08),
činyčiči’ud→tayičiči’ud	(§47,01:29:05),
tarqubai qiriltuq→tarqutai qiriltuq	(§72,02:03:04),
solura→bolura	(§72,02:03:04),

<sup>6</sup> Нака Мичио: «*Чингис хааны магад хууль*», Токио, 1907.

<sup>7</sup> Мүраками Масацүки: «*Монголын нууц товчоон, Чингис хааны үлгэр*», Токио, 1972.

<sup>8</sup> Элдэнтэй, Оюундалай, Асралт: «*Монголын нууц товчоон-ы үгсийн сонгомол тайлбар*», Хөххот, 1980.

<sup>9</sup> Элдэнтэй, Оюундалай, Асралт: «*Монголын нууц товчоон-ы үгсийн сонгомол тайлбар*», Хөххот, 1980.

<sup>10</sup> Озава Шигэо: «*Юан Чао Ми Ши-ийн бүрэн тайлбар*», 6 дэвтэр, Токио, 1984-1989.

<sup>11</sup> Ихмянгадай Иринчин: «*Монголын нууц товчооны уйгуржин монгол үсгийн сэргээлт*», Хөххот, 1987.

<sup>12</sup> Ш.Чоймаа: «*Монголын нууц товчоон, Лувсанданзаны Алтан товч, эхийн харьцуулсан судалгаа*», Улаанбаатар, 2002.

<sup>13</sup> Игор Де Рахевилц: «*Монголын нууц товчоон, 13-р зууны монголын нэгэн туульсын он дараалсан түүх*», Лейдэн, Бостон, 2004.

če'ü→da'u	(§85,02:22:10),
de'üdanr→de'üner	(§101,02:47:01),
jasagen→jasaju	(§132,04:11:01),
sa'ušu→sa'urin	(§142,04:33:08),
nobukin→noyakin	(§166,05:40:02),
čai'un→ya'un	(§169,05:48:05),
ke'elyebei→ke'eldübei	(§170,06:05:10),
yegei qongtaqar→jegei qongtaqar	(§180,06:38:07),
qarbuten→qarbuyu	(§195,07:38:04),
önnen→ünen	(§200,08:14:10),
waigeküi→šinggeküi	(§201,08:19:03),
yuruqan→turuqan	(§202,08:25:09),
bače→basa	(§219,09:24:09),
qubimi→qubilai	(§235,10:10:10),
mingčen→mingqan	(§242,10:23:08),
udan→üjen	(§244,10:430:09),
jiye→jiči	(§257,11:40:05),
uduber→udurar	(§259,11:42:10),
sačid→sayid	(§265,12:06:01),
sojiqas→solangqas	(§274,12:28:01),
lüiyü'er→söyü'er	(§277,12:34:02)

## 2. Хятад хадмалд:

jiang mu zhe→jiang lai zhe (ačiraju)	(§16,01:10:01),
sheng le→zuo le (sa'uba)	(§24,01:15:10),
sui→chu (boroqčın)	(§25,01:16:03),
ban duo du pi you de→ban yun	
du pi you de (dunda ke'elitü)	(§38,01:22:08),
mei de→mü de (eke-yin)	(§43,01:25:08),
da you de→huo you de (qaltu)	(§62,01:43:02),
yi ge→yi tong (qamtu)	(§64,01:44:10),
mo tou→ying tou (tuq)	(§73,02:04:09),
gong zhe→yin zhe (uduridču)	(§79,02:13:06),
duan zhe→qi zhe (unuju)	(§90,02:28:01),
die→song (e'üsgen)	(§94,02:37:03),
jin→zhou (üdür)	(§98,02:42:05),
wen san zhe→kui san zhe (sandurču)	(§110,03:16:05),
zhe→xing (uqa-)	(§118,03:30:10),
ji le de→gao le de (ji'aqsan)	(§121,03:39:04),
cong mei→sai (qačar) mei	(§123,03:43:04),
jiao le→sha le (ala'ad)	(§128,04:03:04),
fan→xiong (aqa)	(§131,04:09:08),
yong→gan (helige)	(§139,04:25:07),
de ren→bai (ja'un) ren	(§150,05:10:01),
zhao→yan (bitün)	(§151,05:11:04),
gu you de→hua you de (keletü)	(§166,05:40:06),

qie→yi (jokiqu)	(§167,05:44:03),
ru zhe→fan zhe (dayijin)	(§177,06:30:03),
jiao ren zhe→jiao ru zhe (oro'ulju)	(§196,07:42:03),
liang→yu (qura)	(§214,09:12:01),
lian tui→lian chui (šibilger)	(§214,09:14:01),
jiao zhong→jiao ju (či'ulqa-)	(§218,09:22:03),
qian mei de→shi mei de (harbad-un)	(§224,09:30:10),
ying zhe→guan zhe (medejü)	(§225,09:36:06),
yu zhe→kan zhe (čabčiju)	(§229,09:47:10),
dao nian→yi nian (geriyes)	(§242,10:24:03),
zi bei→(qabar)	(§242,10:24:06),
wen zhe→kai zhe (ne'ejü)	(§272,12:21:10),
gao yan→gao li (Solangqas)	(§274,12:28:01),
qu zhe→diu zhe (o'ortuqai)	(§278,12:38:03),
guan→gong (ordo)	(§278,12:40:05)

### 3. Товч хятадчилгад:

xiu jiang ye hang→xiu jiang ta (tere) hang	(§72,02:04:01),
lie che ke che er chi hue r hu shan liang jian→dao (kür-) che ke er chi hu er hu shan liang jian	(§94,02:37:08),
hu li wu er→hu zha wu er (huja'ur)	(§177,06:32:08),
su wei shu ri→su wei shu mu (toy-a)	(§229,09:49:08),
fang dao→jing (dalbay-a) dao	(§232,10:06:04),
ba si→yi si (ükübei)	(§240,10:20:03),

### Хоёр. Тонгурсон:

#### 1. Хятад галиглалд:

töre'ünbil→töre'ülbi	(§§17,01:10:05;20,01:12:07),
obotan boqluba→oboqtan boluba	(§42,01:25:02),
jurbu→jubur	(§115,03:25:02),

#### 2. Хятад хадмалд:

zan xun→xun zan	(§83,02:20:07)
-----------------	----------------

### Гурав. Илүүдсэн

#### 1. Хятад галиглалд:

büyü→	(§243,10:25:10)
-------	-----------------

#### 2. Хятад хадмалд:

mo lei shan de→lei shan de	(§57,01:39:05)
----------------------------	----------------

### Дөрөв. Орхигдсон

#### 1. Хятад галиглалд:

töresen→töregsen	(§8,01:05:07),
hunta'u→hunta'u bolba	(§111,03:18:05),

üri→ne'üri	(§118,03:30:05),
eyetüdüjü→eyetüldüjü	(§121,03:38:10),
bošoqa-dur činu→bošoqa-dur činu aju	(§203,08:28:06),

### 2. Хятад хадмалд:

ceng→bu ceng(ese)	(§34,01:21:03),
me→me dao(ke'en)	(§83,02:21:02),
jiao ma→jiao shang ma(morilatuqai)	(§104,03:02:10),
you de→zhou(tenggisge) you de	(§124,03:46:03),
zhe→su zhe (kebtjü)	(§128,04:03:03),
mei→ri mei (üüd)	(§136,04:19:06),
de→shuo de (kelekü)	(§145,04:42:06),
zi de hang→she(kele) zi de hang	(§169,05:49:02),
ling zhe→zhong(Uru'ud) ling zhe	(§176,06:19:10),
le ye zhe→qu le ye zhe (odba)	(§177,06:26:03),
jiao zi de hang→kou(ama) jiao zi de hang	(§214,09:16:07),
di ci→di er ci (nökö'ete)	(§227,09:42:02),
you de→shui you de (usutan)	(§270,12:16:01),
jiao a→jiao ben a (ha'ulqa'asu)	(§279,12:49:05),

### 3. Товч хятадчилгад:

ba a tu→ba a tu er (ba'atur)	(§46,01:29:01),
wo qin ba er he→wo qin ba er he hei (Ökin barqaq)	(§49,01:31:02),
guan zi de shi wu→guan zi ji de shi wu	(§192,07:22:04),
su bie tai→su bie e tai (Sübe'etei)	(§195,07:40:07),
xiao zhuai she wu bai bu→xiao zhuai gong (numu) she wubaibu	(§195,07:41:06),

4-р боть 16-р хуудасны ар нүүр 3-р мөр (§134)-ийн товч хятадчилга дахь «Тоорил Онгийн (Вангийн) цол» гэсэн тухай, Ван Го Вэй хүснэгийн доор захад «монгол эхийг үндэслэвэл, онгийн цол гэсний дараа Тоорил хан Он хан гэж нэрийдсэн нь үүнээс эхлэв гэсэн өгүүлбэр байвал зохино» гэж бичив. Зөв байна. Учир нь хятад галиглалд «Ong qan nere Ongging čingseng-ün nereyi-dügse'er tendeče bolba» гэж бичиж байна.

### Тав. Буруу холбосон:

#### 1. Хятад галиглалд:

qorčiusun ebügen→qorči usun ebügen	(§120,03:36:02),
šigiqutu qugücü→šigiqutuqu gücü	(§202,08:25:04),
badaiqišiliq→badai qišiliq	(§219,09:25:07).

Ван Го Вэй зарим жишээнд: «монгол эх»-ийг үндэслэн зассан буюу нөхвөрлөв гэж тусгайлан тодорхойлжээ. Жишээлбэл, 8-р боть 25-р хуудасны ар нүүр 2-р мөр (§202)-ийн хүснэгийн доор захад «jungsoi гэдэг нь монгол эхийн 3-р боть дахь jangso мөн» гэж бичив. 9-р боть 10-р хуудасны ар нүүр 2-р мөр (§213)-ийн хүснэгийн доор захад «монгол эхийн 3-р ботид

“Cangsi’ud” гэж буй» хэмээн тэмдэглэв. Хятад галиглал нь түүнийг «Biši’ud» гэж буруу авиачилжээ. 5-р боть 12-р хуудасны ар нүүр 3-р мөр (§151)-д Таqai гэх нэг хүний нэрийг нэмж, хүснэгийн дээр захад «монгол эхийг үндэслэн нөхвөрлөв» гэж тэмдэглэв.

Залруулсан, нөхсөн бүх байдлаас үзвэл, “монгол эх”-ийг үндэслэсэн эссэнийг тодорхойлсонгүй засалт цөөн бус байвч, үнэндээ мөн ч хятад галиглалыг баримталжээ. Жишээлбэл, 10-р боть 42-р хуудасны ар нүүр 2-р мөр (§245, *товч хятадчилгын хэсэг*)-д уул нь «долоон хөвгүүд үүдээ бөглөж» гэсэн нэг өгүүлбэр байж, Ван Го Вэй «долоо»-гийн хажууд «зургаа» гэж залруулжээ. Хятад галиглалыг үндэслэн залруулсан гэж хэлж болно. Учир нь хятад галиглалд «jirqo’an» гэж байх бөгөөд хажууд нь «Liu ge» (\*зургаа) гэж хятадаар орчуулсан байна. 11-р боть 19-р хуудасны ар нүүр 4-р мөр (§253. *Товч хятадчилгын хэсэг*)-т Alci гэсэн нэг хүний нэр нэмж «Jürcedei, [Alci], Tolon гурван хүн» болов. 11-р боть 48-р хуудасны ар нүүр 2-р мөр (§260. *товч хятадчилгын хэсэг*)-т «Qongtaqar» гэсэн нэг хүний нэр нэмж «Qongqai, [Qongtaqar], Ğormaqaп зэрэг гурван хүн» болов. Эдгээр бол мөн хятад галиглалыг үндэслэн нөхвөрлөсөн нь илэрхий байна. Хятад галиглалыг сайтар уншиж харгуулах нь «Нууц товчоон»-д залруулга ба судалгаа хийхийн урьдал болно. Зөвхөн товч хятадчилга буюу хятад хадмалыг баримталж, эсвэл хятад галиглалын латинчилгыг түших төдийгөөр «Нууц товчоон»-ы агуулагдахууныг бүрэн гүйцэд ойлгоход бэрх билээ. Энэ нь «Нууц товчоон»-ыг судлагчдын хамтын танилт болсон байна. Гэтэл Ван Го Вэйн үед, Хятадад «Нууц товчоон»-ы судалгаа дэмий хөгжөөгүй байсан бөгөөд монгол хэл мэддэг хятад эрдэмтэн бараг байсангүй. Ийм байдал доор, Ван Го Вэй хятад галиглалыг нарийвчлан уншин хянамгай харгуулсан нь түүний улам шилдэг бүтээл гаргах, нугарал цөхрөлгүйгээр зүтгэх судалгааны овор суртлыг харуулсан бөгөөд залруулж зассан ажлын яс чанар нь нэлээн найдвартай байхыг тодолж байна.

Цөөн бус залруулга, нөхвөр ба тэмдэглэлээс үзвэл, Ван Го Вэй «Нууц товчоон»-ыг харгуулж, судлах явцын дунд нэлээд асуудлуудыг үзэж гарсан байна. “E”-гийн дэвтэр, “Гү”-гийн дэвтэр дэх буруу сийлсэн, буруу хуулсан зэрэг өнгөн дээрх асуудлуудыг мэдсэнээс гадна, хятад галиглал хийгээд хятад хадмал хоёрыг харьцуулахаар дамжин, Мин улсын эхэн үеийн «Нууц товчоон»-ыг хятадчилагчдын орчуулах арга замыг эзэмшсэнээр, уулын зохиол дахь хэлзүйд холбогдсон гүн талын асуудлуудыг ч үзэж гарчээ. Түүний олонх тооны залруулга, нөхвөр, тэмдэглэл өнөөдөр ч гэсэн «Нууц товчоон»-ы харгуулж залруулах ажилд лавлалт, тусламж болох ач холбогдолтой, энэ ажилд түүний үзүүлсэн гавъяа зүтгэлийг хүндэтгэвэл зохино. Хэлзүйн талаар залруулсан жишээнүүд нь голдуу үйл үгтэй холбогдолтой. Жишээлбэл:

#### 1. Үйл үгийн захирах хүсэх төлөвт холбогдох:

zun xun→xun zan (eriye)	(§83,02:20:07),
xia shao→xia →xia zan (ba’uya)	(§142,04:33:07),
hui qu→hui qu nin (qaridqun)	(§148,05:03:08),
gong ru→gong ru wo (oroldusu)	(§164,05:37:10),
si sha→si sha wo (qadquldusu)	(§171,06:07:09),
xu jing→xu jing zan (oqjadqaya)	(§193,07:23:09)

Мин улсын эхин үеийн «Нууц товчоон»-ы хятадчилагчдын хажуу дахь хадмал орчуулга хийх жам ёсоор бол, үйл үгийн ард орших *wo* (\**би*), *zan* (\**бид*), *nin* (\**та*) гурван үсэг тус

тусдаа үйл үгийн захирах хүсэх төлөвийн нэгдүгээр биеийн дан тоо, нэгдүгээр биеийн олон тоо, хоёрдугаар биеийг илтгэсэн тэмдэг үсэг болох бөгөөд эдгээрээ монгол хэлний үйл үгийн захирах хүсэх төлөвийн дагаварт чиглүүлэн хэрэглэдэг.<sup>14</sup> 3-р боть 18-р хуудасны ар нүүр 2-р мөр (§111)-д, хятад хадмал дахь «shì er ku lian» (\*širqulen)-ийг хятад хадмалд нь «zuan ru [wo]» гэж буй. Түүнийг «shì er ku su» (\*шургасу) гэж залруулав.

Эртний монгол хэлний үйл үгийн захирах хүсэх төлөвийн 1-р биеийн дан тооны дагавар бол, «-су/-сү (-su/-sü)», хятад үсгээр авиачлахад «su»-гаар илтгэдэг. «Lian» үсгийн хэлбэр үүн лүгээ ойролцоо болохоор эндүүрэл гарчээ.

## **2. Нөхцөл үйл үгэнд холбогдох:**

3-р боть 34-р хуудасны ар нүүр 4-р мөр (§130)-т, хятад галиглал дахь «nie yi su yi re bie» (\*neyisü irebe)-ийг хятад хадмалд нь «xiang he» гэж буй. Түүнийг «nie yi lian yi re bie» (\*нийлэн ирэв) гэж залруулав. “-n” бол монгол хэлний хам нөхцөл үйл үгийн дагавар болох бөгөөд энд өмнөх үе “-le” лүгээ холбож, “-len” болно. Хятад үсгээр авиачлахад голдуу “lian”-аар илтгэдэг. “Su” үсгийн хэлбэр үүн лүгээ ойролцоо болохоор эндүүрэл гарчээ.

1-р боть 4-р хуудасны зөв нүүр 5-р мөр (§6)-т хятад галиглал дахь «ögtegsen bö'esü»-ийг хятад хадмалд нь «yu le de you lai» (\*өгтсөн бөлгөө) гэж буй. Түүнийг «yu le de you a» (\*өгтсөн бөгөөс) гэж засав.

7-р боть 38-р хуудасны зөв нүүр 2-р мөр (§195)-д, хятад галиглал дахь «a wu er la a su» (\*a'urła'asu)\*-ыг хятад хадмалд нь «nu ke» (\*уурлаж болох) гэж буй. Түүнийг «nu a» (\*уурлаваас) гэж залруулав.

-«'asu/-'esü» (-basu/-besü) бол эртний монгол хэлний болзох нөхцөл үйл үгийн дагавар болно, хятад үсгээр авиачлахад «a su, e su, ba su, bie su»-гаар илтгэж, хятад хадмалд “a” гэж тэмдэглэдэг. “Ke” үсгийн хэлбэр үүн лүгээ ойролцоо болохоор эндүүрэл гарчээ.

## **3. Үйл үгийн цагийн хэвийн дагаварт холбогдох:**

7-р боть 38-р хуудасны ар нүүр 4-р мөр (§195)-д хятад галиглал дахь «ha er bu tian» (\*qarbuten)-ыг хятад хадмалд нь «she you» (\*харвана) гэж буй. Түүнийг «ha er bu you (\*харваюу)» гэж залруулав. «-yu/-yü» бол монгол хэлний үйл үгийн одоо цаг, ирээдүй цагийг заах дагаврын нэг болно. Хятадаар авиачлахад «you»-гаар илтгэдэг. «tian» үсгийн хэлбэр үүн лүгээ ойролцоо болохоор эндүүрэл гарчээ.

4-р боть 34-р хуудасны ар нүүр 3-р мөр (§142)-т, хятад галиглал дахь «ya bu zhu wei» (\*yabuji'ui)-ыг хятад хадмалд нь «xing le you wei» (\*яв?) гэж буй. Түүнийг «xing le you lai» (\*явжухуй, явав зэрэг) гэж залруулав.

-«ju'ui/-jü'üi» бол эртний монгол хэлний үйл үгийн өнгөрсөн цагийг заах дагаврын нэг болно. Хятадаар авиачлахад «zhu wei»-гээр илтгэж, хятад хадмалд нь «you lai» гэж тэмдэглэдэг.

## **4. Үйл үгийн хэвийн дагаварт холбогдох:**

12-р боть 45-р хуудасны ар нүүр 12-р боть 45-р хуудасны ар нүүр 5-р мөр (§299)-д, хятад галиглал дахь «a ha la hei da ba» (\*aqalaqđaba)-ийн хятад хадмалд нь «bi wei zhang le» (\*тэр

<sup>14</sup> Ардаажав: «Монголын нууц товчооны шинэ орчуулга тайлбар», Хөххот, 2005

ахлагдав) гэж буй. Түүнийг «bei wei zhang le» (\*ахлагдав) гэж залруулав.

«-qda/-gde» бол монгол хэлний үйл үгийн бусдад үйлдэгдэх хэвийн дагаврын нэг болно, Хятадаар авиачлахад «hei da/ ke die»-гээр илтгэдэг, хятад хадмалд «bei» гэж тэмдэглэдэг. «bi» үсгийн хэлбэр үүн лүгээ ойролцоо болохоор эндүүрэл гарчээ.

### 5. Тэмдэг үйл үгийн үгүйсгэх хэлбэрт холбогдох:

10-р боть 35-р хуудасны зөв нүүр 2-р мөр (§245)-д, хятад галиглал дахь «bo su ai wu du wu ye» (\*bosu'ai üdü'üi-e)-ийг хятад хадмалд нь «qi lai hang» (\*босохыг) гэж буй. Түүнийг «qi wei hang» (\*босоогүйеэ) гэж залруулав.

-üdü'üi-e бол оршихын тийн ялгалын дагавар –e (хятад хадмалд hang гэж тэмдэглэдэг)-тэй хэлбэр мөн. «-üdü'üi» бол эртний монгол хэлний тэмдэг үйл үгийн үгүйсгэх дагаврын нэг болно, хятадаар авиачлахад «wu du wei» гэж илтгэж, хятад хадмалд «wei» гэж орчуулдаг. «lai» үсгийн хэлбэр үүн лүгээ ойролцоо болохоор эндүүрэл гарчээ. Дээр дурдсан Ван Го Вэйн засвар нөхвөр бүр Мин улсын эхний үеийн хятадчилагчдын хадмал орчуулгад холбогдох жам ёс лугаа нийцэж байх юм.

Онц зарим залруулгын жишээ нь нэр үгийн тийн ялгал лугаа холбогдолтой. Жишээлбэл:

#### 1. Үйлдэхийн тийн ялгалд холбогдох

8-р боть 2-р хуудасны зөв нүүр 3-р мөр (§198)-д, хятад галиглал дахь «a lai yi ya er» (\*Arai-iyar)-ыг хятад хадмалд нь «shan ming» (\*уулын нэр) гэж буй. Түүнийг «shan ming yi zhe» (\*...нэртэй уулаар) гэж залруулав.

-iyar/-iyer бол монгол хэлний нэр үгийн үйлдэхийн тийн ялгалын дагаврын нэг болно, Хятадаар авиачлахад «yi ya er/ yi ye er» гэдэг. Энэхүү дагаврын нөгөө хэлбэр нь «-bar/-ber» (-'ar/'er) бөгөөд хятадаар авиачлахад «ba er/ bie er» (a er/ e er) гэдэг. Үйлдэхийн тийн ялгалыг хятад хадмалд олон янзын үгээр илтгэж буй. Тухайлбал «jiao, yong, li, hang, yi zhe» гэх мэт. «Yi zhe»-г олон байдалд хэрэглэдэг, «ёсоор, зарлигаар, үгээр» зэрэг жишээнүүдийн доторх «yi zhe» бол журамлах гэсэн утгаар хэрэглэдэг бөгөөд «мөрөөр, алархайгаар, тэргүүрээр, замаар» зэрэг жишээнүүдийн доторх «yi zhe» бол «...ийн дагуу» гэсэн утгаар хэрэглэнэ. «Арай»-гаар гэсэн жишээний тухай, 11-р боть 36-р хуудасны ар нүүр 4-р мөр (§257) дахь хятад хадмалд мөн «a la yi ya er»(\*Ara-iyar-Arai-'ar) харагдаж, хятад хадмалд нь «di ming yi zhe» (\*...нэртэй газраар) гэж буй, «a la yi ya er» буюу «a lai yi ya er», монгол эхэд нь бүр «Арай»-гаар гэх ёстой, хятад галиглал нь монгол хэлний ярианы аялгуутай ойролцоо байна. Arai гэдэг нь Арай даваа билээ. «yi zhe»-г хэрэглэсэн олонх жишээ ба 257-р зүйлийн хятад хадмалд нь 198-р зүйлийн хятад хадмалын «shan ming»-гийн дараа уул нь «yi zhe» гэх үг дутагдсаныг гэрчилж байна. Ван Го Вэйн нөхвөр оруулсан нь Мин улсын эхний үеийн хятадчилагчдын орчуулах зарчимтай нийцэж байна.

#### 2. Өгөх оршихын тийн ялгалд холбогдох

8-р боть 39-р хуудасны ар нүүр 5-р мөр (§206)-д, хятад галиглал дахь «wu lu he» (\*uruq-a)-г хятад хадмалд нь «zi sun hao» (\*ураг сайн) гэж буй. Түүнийг «zi sun hang» (\*урагаа, урагт) гэж залруулав. «uruq-a»-ын а (/e) бол эртний монгол хэлний өгөх оршихын тийн ялгалын



дагаврын нэг болно. Олонхдоо өмнөх гийгүүлэгчтэй нийлээд нэг үе болдог, «Нууц товчоо» түүнийг хятадаар авиачлахад тогтсон үсэг байхгүй, хятад хадмалд нь олонхдоо «hang» гэж тэмдэглэдэг. «hao» үсгийн хэлбэр үүн лүгээ ойролцоо болохоор эндүүрэл гарчээ.

Дээр дурдсан Ван Го Вэйн засалт бол монгол хэлний нэр үгийн тийн ялгалын мэдлэг ба Мин улсын эхний үеийн хятадчилагчдын зарчмыг ойлгож авсан суурин дээр биелэгдсэн юм. Тэр 1-р боть 4-р хуудасны зөв нүүр 5-р мөр (§6)-ийн шугамын гадна «утгын ёсноос үзвээс «you lai» (\*өнгөрсөн цагийг илтгэхэд хэрэглэх үг) гэсэн нь «you a» (\*нөхцөл болзлыг илтгэхэд хэрэглэх үг) болвоос зохимой» гэж тэмдэглэжээ. Энэхүү «утгын ёсон» гэдэгт учир дээрээ хэл зүйн ёс учир багтаж байна.

«Нууц товчоон»-ы цөөн бус үгст хятад хадмал дутагдаж байна. Анх алхмын бүртгэлээр 100 шахам буй. Уламжлагдан шилжихийн явцад орхигдож хасагдсаныг гаргавал, нэлээд ихэнх хэсэг нь уулын хятадчилагчид эс орчуулснаас болсон бололтой. Ван Го Вэй тэдгээрийн дотроос 20 гаруй хоосон орыг орчуулан нөхвөрлөжээ.

Боть (зүйл)	Хятад галиг	Ван Го Вэйгийн засвар, нөхвөр
Vol.2,9г.1.3 (§77)	bilji'ur	«bilji'ur» Нака (мичио) авгай «you que» (*хайрууцай) гэж орчуулав.
Vol.2,47г, 1.2 (§101)	qa'atai	«qa'atai»-ын хажууд «men you de» (*хаалгатай) гурван үсэг байвал зохино.
Vol.2,50v, 1.5 (§103)	qarča-yin	«qarča» Нака авгай «yi» (*шоргоолж) гэж орчуулав.
Vol.3,4г, 1.2 (§105)	önör	önör. Нака авгай «kou zi» (*товч) гэж орчуулав. Дараах 8-р хуудасны хятад хадмалыг үндэслэв.
Vol.3,18г, 1.4 (§111)	qatar	«qatar» Нака авгай «wai maо» (*гадар байдал) гэж орчуулав.
Vol.3,18г, 1.5 (§111)	qunar	«qunar» Нака авгай «fu zhuang» (*хувцас хунар) гэж орчуулав.
Vol.3,19г, 1.4 (§111)	qaratu	«qaratu» Нака авгай «hei» (*хар) гэж орчуулав.
Vol.3,46v, 1.4 (§124)	onglajidqun	«onglaji»-ын хажууд «ci» (*чичих, хатгах) гэсэн үсэг байвал зохино.
Vol.3,47г, 1.3 (§124)	qola-yin	«qola-yin»-ын хажууд «jian ming» (*сумны нэр) гэсэн хоёр үсэг орхигдов.
Vol.4,13г, 1.1 (§133)	öterlen	«öterlen»-ий хажууд «zuo ji» (*түргэлэн) гэсэн хоёр үсэг орхигдов.
Vol.4,13г, 1.1 (§133)	igtünejü	«ig» гэсэн нь «ireg» гэвэл зохино. Хажууд нь «lai» (*ир-) гэсэн үсэг орхигдов.
Vol.4,16г, 1.2 (§134)	tedüi	1-р боть 38-р хуудсанд «tedüi»-ийн хажууд «bian» (*төдий, даруй) гэж буй.
Vol.4,40г, 1.1 (§145)	olun	«olun»-ы хажууд «de» (*ол-) гэсэн үсэг байх ёстой.

Vol.5.1r, (§148)	1.5	keyisgen	«keyisgen»-ий хажууд «gua» (*хийсгэ-) гэсэн үсэг орхигдов.
Vol.5.37v, (§164)	1.3	adarda'asu adarqan-i	1-р боть 28-р хуудсанд «adarq» (*адрагч гэвэл зохино)-г хятад хадмалд нь «jian die» (*тагнуул) гэж буй, Нака авгай «li jian» (*хагацуулах) гэж орчуулав.
Vol.6.16v, (§174)	1.2	e l b e s ü n jalama	«elbesün» тухайлбал «erі, erin»-ий хувиралт, jalama тухайлбал «jal»-ын хувиралт, нийлээд «xun gaо» (*эрин заалдах)-ийн явдлыг хэлж буй. Товч хятадчилгад «qi dao» (*даатган залбирах) гэж зөв орчуулав.
Vol.6.46r, (§183)	1.2	urbang	«urbang»-г Накагийн дэвтэрт «urno» гэж буй. Хажууд нь «tu» (*шороо газар) гэсэн үсэг орхигдов.
Vol.7.10r, (§189)	1.3	elbesü-'er	«elbesün» гэдэг нь «qi dao» (*даатган залбирах)-ын явдлыг хэлж буй. «-er» бол «yi» (*-аар <sup>1</sup> )-г хэлж буй.
Vol.7.10r, (§189)	1.4	ai torluq	Доорхи «aiyi»-г хятад хадмалд нь «tan sheng» (*шүүрс алдах дуу) гэж буй, «torluq»-ыг Нака авгай «nuo» (*дорой, буурай) гэж орчуулав.
Vol.7.11r, (§189)	1.1	čo'eked	Хажууд нь «shao» (*цөөн) гэсэн үсэг байвал зохино.
Vol.7.13v, (§190)	1.3	ni'udqun	«ni'udqun»-ыг Нака авгай «mi mi» (*нууц) гэж орчуулав. «mo» (дуугүй) гэвэл зохино.
Vol.9.2v, (§209)	1.2	(Bedü'ün-ü) mojirqaq-un	«Bedü'ü»-г 3-р ботид «moči bedü'ün» гэж буй, «moči» бол «mojir»-ын товчлол, товч хятадчилгад «xing niu» (*зөрүү) гэж буй. Тэр зөрүү зантай болохоор «moči bedü'ün» гэсэн хоч нэр олов.

Үүнд өмнө хойнох өгүүлбэр буюу товч хятадчилгад үгсийн утгыг лавлаж олох үгнүүд бараг 10 буй. Тухайлбал «zuo ji» (үтэрлэн), «bian» (төдий), «de» (олон), «gua» (хийсгэн), «jian die» (адарган), «qi dao» (элбэсэн жалма), «tan sheng» (ай торлог), «shao» (цөөхөд), «mo» (нуудахун), «xing niu» (можирхаг) зэрэг буй. Үүнээс гадна арваад нөхвөр тэмдэглэлд Нака Мичиогийн «Нууц товчоон»-ы япончлого «Чингис хааны магад хууль»-ыг лавласан байна. Зарим нөхвөр тэмдэглэл буруудсан нь илхэн байна. Жишээлбэл «yi» (шоргоолж), «kou zi» (товч), «lai» (ир-) зэрэг болно.

Үүнээс гадна, зарим буруу засвар, буруу нөхвөр бас харагдаж байна. Жишээлбэл:

1-р боть 4-р хуудасны ар нүүр 1-р мөр (§6) дэх хятад галиглал «Dobun mergen de'ü—yü'en üjer-e ilebe» гэж буй, түүний доторх «-yü'en»-ийг «өмнөх хэсэгт адилаар –de'en гэвэл зохино» гэж тэмдэглэв.

3-р боть 2-р хуудасны зөв нүүр 2-р мөр (§104) дэх хятад галиглал «qamtudqalduju» гэж буй. Түүнийг «qam, гэдэг нь –qa гэвэл зохино» гэж тэмдэглэв. Мөн 3-р боть 6 -р хуудасны зөв нүүр 1-р мөр (§105) дэх «qamqa'ulsun», 3-р боть 11 -р хуудасны ар нүүр 1-р мөр (§108) дэх «qamtudju» зэрэг үгийг «qam, гэдэг нь –qa гэвэл зохино» гэж тэмдэглэв.

5-р боть 49-р хуудасны ар нүүр 5-р мөр (§169) дэх хятад галиглал «qoš» гэснийг «qoq» байх бололтой гэж тэмдэглэв.

- 10-р боть 45-р хуудасны зөв нүүр 2-р мөр (§246) дэх товч хятадчилга «zhi di san ri jiang wan» (\*гутгаар өдрийн үдэш болохуйяа) гэж буй. Түүний доторх «wan» (\*үдэш, орой)-ийг «xiao» (\*үүр өглөө) гэвэл зохино» гэж тэмдэглэв. Буруу болсон. Учир нь хятад галиглалд нь «sōni» гэж буй.
- 3-р боть 3-р хуудасны ар нүүр 1-р мөр (§104) дэх товч хятадчилга «... di mian li zhu, you wo zhe li qi er wan jun ma ...» (\*...газарт сууж буй миний эндээс хоёр түмэн цэрэг үүсгэж...) гэж буй. Түүний доторх «you» (\*буй) гэсэн үсгийн хажууд «zhe» (\*-ж) гэж засав. Буруу болсон. Учир нь хятад галиглалд нь «būi je» гэж буй. Товч хятадчилгад «...di mian li zhu you, wo zhe li...» (\*газарт сууж буй, миний эндээс...) байвал зохино.
- 9-р боть 18-р хуудасны зөв нүүр 1-р мөр (§214) дэх товч хятадчилга «que le tang yin» (\*шөл ундаа байхгүй) гэж буй. Түүний доторх «yin» (\*ундаа) гэсэн үсгийн хажууд «fan» (\*хоол) гэж засав. Буруу болсон. Учир нь хятад галиглалд нь «šülen ügei» гэж буй.
- 10-р боть 10-р хуудасны зөв нүүр 5-р мөр (§234) дэх товч хятадчилга «guan shan ma nei, jiao shou shi tuo kun suo zhe» (\*агтсаас, асарч уях дээс ачиж явуултугай) гэж буй. Түүний доторх «kun» (\*уях)-г «xi» (\*нарийн) гэж засав. Буруу болсон. Учир нь хятад галиглалд нь «aqtas-ača asaraju hö'öšin (-h'ö'öga гэж буруу сийлсэн) аciju yabutuqai» гэж бичиж байна. Товч хятадчилгад «guan shan ma nei jiao shou shi..tuo wang suo zhe» (\*агтсаас асарч, өөшин ачиж явуултугай) гэвэл таарна. «hö'öšin» (\*өөшин)-ий хятад хадмалд нь «wang suo» гэх бөгөөд товч хятадчилгын «kun suo» гэдэг нь түүний буруу сийлмэл мөн.
- 1-р боть 39-р хуудасны зөв нүүр 5-р мөр (§57)-д, хятад галиглал дахь «qabirqa-ta»-ыг хятад хадмалд нь «mo lei shan de» (\* хавиргыг давсан, цээж давсан) гэж буй. Ван Го Вэй хүснэгийн доор захад «lei shan-ыг монгол эхэд «ha bi er ha er» (\*хавиргаар) хэмээмүй, энд «хавиргыг давсан» гэж хажуу дахь орчуулга хийхдээ «mo» (\*давсан) гэсэн үсэг нь доорх «mo xi de» (\*өвдөг давсан) гэсэн үгийн нөлөөгөөр илүүц болов» гэж тэмдэглэв. «qabirqa-ta» бол өгөх оршихын тийн ялгалын шинжтэй хэлбэр болно. «Нууц товчоон»-ы товч хятадчилгад үүнийг орчуулсангүй. Энэхүү үгийг шууд орчуулбал «хавирганд хүртэл» тухайлбал «хавиргыг давсан» гэсэн утгатай. mo (\*давсан) гэсэн үсэг илүүдсэнгүй. Хэрэг дээрээ залгаад «ebüdüg-te» гэсэн хятад галиглалын хажууд «mo xi de» (\*өвдөг давсан) гэж орчуулсныг шууд орчуулбал мөн л «өвдөг хүртэл» гэх болохоор илүүдсэн утга байхгүй.
- 4-р боть 34-р хуудасны зөв нүүр 4-р мөр (§142)-д, хятад галиглал дахь «ke bei» (\*ke būi)-ийг хятад хадмалд нь «hu mei you» (\*хамгаалууд буй) гэж буй. Түүнийг «hu» (\*хамгаалал) нь «hua» (\*үг)-ийн ташаа бололтой» гэж тэмдэглэв. Үнэндээ «ke» гэдэг нь «ke [ti]» (\*ked. хэд) байвал таарна. Энэ бол «ken»-ий олон тооны хэлбэр болно. Иймээс «hu» бол «shui» (\*хэн)-ий ташаа үсэг болжээ. «Нууц товчоон»-д үүнээс бус гурван газарт (§170,195) «ke ti» (\*хэд) байх бөгөөд хятад хадмалд нь бүр «shui mei» (\*хэн-ий олон тоо) гэж бичив.
- 8-р боть 27-р хуудасны зөв нүүр 1-р мөр (§202)-ийн хятад галиглал дахь «ye lian ta ben» (\*yeren tabun)-ыг хятад хадмалд нь «jiu shi wu» (ерэн тав) гэж байхад, Ван Го Вэй «ye lian» (\*ерэн)-ийг «ye su» (\*ес) гэвэл зохино» гэж тэмдэглэжээ. Буруу болсон нь илэрхий.
- 12-р боть 9-р хуудасны ар нүүр 4-р мөр (§267) дэх хятад галиглалын «ne wu ti» (\*nu'ud)-г хятад хадмалд нь «er [mei]» (\*хөвгүүн) гэж бичив. Ван Го Вэй «ne-г «ke» гэвэл зохих мэт» гэж тэмдэглэжээ. «nu'ud» бол «нуган»-ы олон тооны хэлбэр, «ke wu ti» (\*kō'üd хөвгүүд) гэсэн хэлбэртэй нэг үг биш.

- 12-р боть 8-р хуудасны зөв нүүр 5-р мөр (§266)-ийн хятад галиглал дахь «huo er li» (\*qorri)-г хятад хадмалд нь «yi jin» (\*хувцасны хормой) гэж буй. Ван Го Вэй, “Гү”-гийн дэвтрийг үндэслэн «li» (дотор гэсэн утгатай үсэг)-ийг ондоо «li» үсэг (ёс зэрэг утгатай)-ээр солин засав. Хэрэг дээрээ “Гү”-гийн дэвтэр дэх «li» бол «mai»-тай төсөөтэй болохоор эндүүрэл гарчээ. «huo er mai» (\*qorntui) гэдэг нь хормой болно.
- 7-р боть 41-р хуудасны ар нүүр 1-р мөр (§195)-ийн товч хятадчилга дахь «lian chuan tou» (\*цөм нэвтрэн) гэдгийн «lian» үсгийн дараа «jia» (\*хуяг) үсэг нөхвөрлөсөн нь бурууджээ. Учир нь хятад галиглал дахь «kelkitele ülketele qarbuyu»-ыг хятад хадмалд «zhi lian le zhi chuan le she you» (\*холботол, нэвтэртэл харвана) гэж орчуулж байх бөгөөд энэ нь олон хүмүүсийг нэгтгэн харваад нэвтэлнэ гэсэн утгатай.
- 9-р боть 14-р хуудасны зөв нүүр 1-р мөр (§214)-ийн хятад галиглал дахь «nōkō'e qar-iyar-iyan»-ыг хятад хадмалд «na ge shou jiao zi de hang» (\*нөгөө гараараа) гэж буй. Ван Го Вэй «jiao» (\*бусдаар үйлдүүлэх хэвийг илтгэдэг) үсгийн өмнө «shou» (\*гар) гэсэн үсэг нөхвөрлөжээ. Буруу болсон. Учир нь «shou» гэсэн үсэг орхигдсонгүй. Зөвхөн өмнөх үг «nōkō'e»-ийн хятад хадмалд буруу оршсон байна.

Үнэнийг хэлэхэд, «Нууц товчоон»-ыг харгуулан залруулга хийхэд эртний монгол хэл, үсэг бичиг хийгээд хятад хэлний авианы зүй зэрэг талаар тун өндөр шаардлага тавигддаг юм. Энэхүү ажил бол аль ч судалгаатанд боловч бүр шалтгаан болно. Төгс төгөлдөр болгохуйяа их бэрх, алдаа гарах нь зайлшгүй хэрэг, монгол хэлний суурь байхгүй Ван Го Вэйг нэн юун өгүүлэх ажээ.

«Нууц товчоон»-ы судлалт ойрын жилүүдээс нааш бас нэг шинэ өрнөлт гарч, орчуулж тайлбар хадсан хэдэн зүйлийн дэвтэр урьд хожид гарч ирлээ. Гэтэл бүх талыг хамарсан чанарлаг харгуулсан дэвтэр олдохуйяа мөн бэрх байсаар. Ингэхлээр Ван Го Вэй хийгээд Элдэндэй, Оюундалайн дараагаар «Нууц товчоон»-ы эх зохиолыг харгуулж залруулга хийх ажил ихээхэн шиг давшихыг хүсэн эрмэлзэж байна.

1. “А” дэвтэр дэх «Е Дэ Хуй»-н оршил, Рувань Юаний бичсэн хураангуй товчийн дараах нэг нүүр сул цаасанд Ван Го Вэй нөхвөр тэмдэглэл бичиж «хөхөгчин үхэр жилийн найман сард Гуан Вэнь (\*Ван Го Вэй-н өөрийн нэрийдэл) тэмдэглэв» гэж бичжээ. Тус нүүрийн хүснэгийн дээр захад бас нэг нөхвөр тэмдэглэл бичиж «хөхөгчин үхэр жилийн найман сард Гуань вэн (\*Ван Го Вэй-н өөрийн нэрийдэл) тэмдэглэв» гэж бичжээ. Тус нүүрийн хүснэгийн дээх захад бас нэг нөхвөр тэмдэглэл бичиж «есөн сарын шинийн нэгнээ бас тэмдэглэл хийв» гэж бичив. Энэхүү хөхөгчин үхэр жил бол 1925 он болно. 9 сарын шинийн нэгэн (хөхөгчин гахай өдөр) бол аргын улирлын 10 сарын 18-ны өдөр болно. Тус дэвтрийн гол бүлгийн ард «хөхөгчин үхэр жилийн есөн сард Лин ши газар дахь Ян овогтны дэвтрээр харгуулжээ. Гуань Вэн тэмдэглэв», «Мөн сард бас монгол эх лүгээ харгуулж, зохих үг өгүүлбэрийг нэмэв» гэж нөхвөр тэмдэглэл хийжээ.
2. Ван Го Вэй “В” дэвтрийн ар дахь сул цаасанд их хэмжээний нөхвөр тэмдэглэл хийж, тэмдэглэлийн эцэст «хөхөгчин үхэр жилийн арван сарын тэргэл өдөр Хайнин газар дахь Ван Го Вэй [бичив]» хэмээв. Энэхүү 10 сарын тэргэл өдөр бол аргын улирлын 11 сарын 16 болно.

3. Ван Го Вэй “А” дэвтрийн гол бүлгийн ар талд өөр нөхвөр тэмдэглэл хийж «улаан барс жилийн 10 сард Хан Пэн Лоу асарт хадгалж байсан Гү Жиян Фин (\*Гү Гуань Чийн цол)-ий харгуулж хуулуулсан уулын дэвтрийг зээлж нэгэн удаа харьцуулан засаж үзлээ» гэж бичжээ. В дэвтрийн гол бүлгийн ард «улаан барс жилийн арван сард Хан Пэн Лоу асарт хадгалж байсан Гү Жянь Фин-ий гараараа харгуулан хуулуулсан дэвтэр лүгээ харьцуулан засаж үзлээ» хэмээж, дэвтрийн эцэст бичсэн нөхвөр тэмдэглэлдээ «улаан барс жилийн арван сард Хан Пэн Лоу асраас зээлж аваад нэг удаа харгуулан, өдий төдий үсгийн ташааг залруулав. хорин хоёрын үдэш зулын гэрэл доор [Ван] Го Вэй тэмдэглэв» гэв. Энэхүү улаан барс жил бол 1926 он болно. 10 сарын 22-ны өдөр бол аргын улирлын 11 сарын 26-ны өдөр болно.
4. “Гү”-ийн дэвтрийн эхэнд «Пү Цзэн Сян»-ы 1932 он (хар бичин жил)-д үсэн бийрээр бичсэн тэмдэглэл буй. Үүнд дурдсан нь: *Хан Пэн Лоу* асар тус дэвтрийг худалдан авахад тэр «бичгийн үнийг зөвдөлцөхөд оролцсон» бөгөөд хожим нь тус дэвтрийг “Хан Пэн Лоу асар”-аас зээлж Чэнь Юаний харгуулан залруулахад хэрэглэсэн билээ. Удалгүй Японы нисэх онгоц Шанхай хотыг бөмбөгдөж, Хан Пэн Лоу асар дайрагдан сүйрсэн байна. Ингэхлээр тэр сэтгэл хөдөлж «Тус ном надад зээлэгдсэнээр гамшгаас хэлтэрчээ. Үүнийг их аз завшаан бус гэж хэлж болно уу», «Тус ном 20 жилийн өмнө миний гараар дамжин олдогдож, 20 жилийн дараа мөн миний гараар дамжин бүрэн бүтнээр хамгаалан хадгалав. Бодоход сансар ертөнцөд тогтоосон хувь заяатай шиг, харин би энэхүү тэнгэрийн гавьяа зүтгэлийг яаж бүр аминдаа татаж болох юм буй» гэжээ.
5. Зүүлтийн 1, 3-ыг лавламу.
6. Бүртгэлээр А дэвтэрт бараг 59 газар, В дэвтэрт бараг 40 газар засжээ.
7. Бүртгэлээр А дэвтэрт 3 газар засжээ.
8. Бүртгэлээр А дэвтэрт бараг 88 газар, В дэвтэрт бараг 77 газар засжээ.
9. Жишээлбэл: 6-р боть 38-р хуудасны ар нүүр (§180)-ийн хятад галиглал дахь «jеgei qongtaqar»-ын тухай, Ван Го Вэй хүснэгийн дээр захад «jеgei qongtaqar» гэхийг зүй нь 4-р ботийн ёсоор «jеgei qongtaqar» болгомуй, «Шэн-у цинь-чжэн-лу»-д «jеgei qongtaqar» гэж бичиж буй, иймээс «уе» гэгч «je»-ийн жишээ бичлэг болохыг мэдэв» гэжээ.
10. Ван Го Вэй “В” дэвтрийн гол бүлгийн дараа хийсэн нөхвөр тэмдэглэлдээ «Гуань Вэн, хянан хуулуулсан дэвтрийг үндэслэн харгуулан залруулахдаа улаан бийрээр мөрийн хажууд бичлээ. Хянан хуулуулсан дэвтэрт бас буруудсан зүйл буй, гүйлгэн уншихын дагуу нийт 149 газрын ташаа үзэж гарсан бөгөөд хүснэгийн гадна тэмдэглэжээ» гэв.
11. Одоогоор Хятадын Төрийн номын сангаас зөвхөн энэхүү 2 дэвтрийн микрофильмийг зээлж үзүүлнэ. Үүнд зохих тооны залруулгыг тэмдэг хийгээд хаясан бөгөөд заримууд нь тодорхой танигдахгүй тул юу болохыг магадлахуйяа бэрх, ингэхлээр их төлөвийн бүртгэл хийх төдий.

12. Элдэндэй, Оюундалайн «Монголын нууц товчооны харгуулсан дэвтэр» (Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо 1980 он)-д зөвхөн хятад эхийн галиглалыг харьцуулан залруулжээ.
13. Тус өгүүлэлд оруулсан жишээнүүдийг үндсэндээ “Тү”-ийн дэвтэрт Ван Го Вэйн харгуулж зассан нөхвөрлөсөн агуулгаас сонгож авчээ.
14. Одоо олдож байгаа дэвтрүүдээс үзвэл энэхүү жам ёс тууштай биелэгдсэн биш, цөөхөн бус үйл үгийн захирах хүсэх төлөвийн хятад хадмалд тэмдэг үсэг оруулсангүй. Ван Го Вэйн нэмсэн нь өчүүхэн нэг хэсэг болно.